



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/590

Чингис хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 3 аж ахуй байгууллагад эзэмшүүлсүгэй.

2. Аж ахуй нэгж байгууллагын эзэмшил газрын хэмжээ байршлыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг аж ахуй нэгж байгууллагуудын захирал нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/311, 2013 оны А/194, 2013 оны А/192 дугаар захирамжуудыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

ЦИДЭРБАТ

231011030

Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 11 өдрийн 11/15/30
дугаар захирамжийн хавсралт

Хэрлэн суманд газар эзэмшиж байгаа аж ахуй нэгжийн
газрын байршил, хэмжээ зориулалт

Д/д	Иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Талбайн хэмжээ /м ² /	Байршил	Газар эзэмшлийн зориулалт	Хугацаа /жил/
1	"Хан бүргэд хэрлэн" ХХК	4191625	29737м ²	Хэрлэн сум 5-р баг Тариаланчдын гудамж	Үйлдвэрлэл	21
2	"Хан бүргэд хаан" ХХК	4189493	2636м ²	Хэрлэн сум 1-р баг Тэмүүжингийн гудамж	Үйлчилгээ	22
3	"Хан бүргэд номин" ХХК	4189507	2870м ²	Хэрлэн сум 1-р баг Тэмүүжингийн гудамж	Үйлчилгээ	43